



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 7/01

Эрдэнэт

Баян-Өндөр уулыг орон нутгийн
хамгаалалтад шинэчлэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.к дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Байгаль орчны сайдын 2000 оны 7 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг:Баян-Өндөр уулыг 15 жилийн хугацаатайгаар орон нутгийн хамгаалалтад авч, түүний хилийн зааг, талбайн хэмжээг нэгдүгээр, орон нутгийн хамгаалалттай Баян-Өндөр ууланд мөрдөх журмыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр:Аймгийн Засаг дарга Д.Батлутад ДААЛГАХ нь:

2.1.Цаашид Баян-Өндөр уулыг хамгаалах ажлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв болон олон улсын төсөл хөтөлбөрт хамруулан шийдвэрлэх.

2.2.Баян-Өндөр уулыг бүхэлд нь хамгаалах асуудлаар Булган аймагтай хамтран ажиллах, энэ талаар холбогдох яаманд тавьж шийдвэрлүүлэх.

2.3.Байгаль орчныг хамгаалах ажлыг эрчимжүүлж, жил бүрийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнах.

Гурав:Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 66, 2005 оны 52 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100144